

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь МРЦМ/202212217 дугаар бүхий Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын “Бор-Өндөр УБҮ”-т “Шатах тослох материалын агуулахын зураг, төсөв” худалдан авах тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
  - Байгууллагын ерөнхий танилцуулга
  - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
  - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойших байдлаар/ ирүүлнэ.
  - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
  - Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсвэл үйлчлүүлэлгчийн тодорхойлолт.
3. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2022 оны 04 дүгээр сарын 29–ны өдрийн 09 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2022 оны 05 дугаар сарын 02–ны өдрийн 09 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ